



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 10 сарын 04 өдөр

Дугаар А/336

Мөрөн сум

Ажлын хэсэг байгуулж, албан даалгаврын
хэрэгжилтийг хангах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, Усны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.4, Хог хаягдлын тухай хуулийн 9.3.11, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2022 оны 09 дүгээр сарын 19-ны өдрийн 11 дүгээр албан даалгаврыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан даалгаврыг орон нутагт хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, сумдыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах, ажлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллаж, ажлын үр дүн, тайлан мэдээг Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон аймгийн Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулах чиг үүрэг бүхий ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Аймгийн нутаг дэвсгэрт рашаан, аялал жуулчлал, амралт зугаалгын газар, төв суурин газрын дагуух усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн дэглэмийг мөрдүүлэх, хил заагийг тэмдэгжүүлэх ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулж ажиллахыг сумдын Засаг дарга, Сав газрын захиргааны дарга нарт тус тус даалгасугай.

3. Усан сан бүхий газрын онцгой болон энгийн хамгаалалтын бүс, усны эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсэд байгаа стандартын шаардлага хангаагүй нүхэн жорлон, хаягдал усны нүхийг буулгах, ариутгал халдваргүйжүүлэлт хийж булах ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 10-ны өдрийн дотор хийж гүйцэтгэн, тайлан мэдээг аймгийн ажлын хэсэгт ирүүлж ажиллахыг сумдын Засаг дарга, Сав газрын захиргааны дарга нарт үүрэг болгосугай.


4. Ажлын хэсэг 2022 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн дотор Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын албан даалгавар аймгийн Засаг даргын захирамжийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөө, сумдад өгөх зөвлөмжийг танилцуулан, 2022 оны 10 дугаар сарын 20-ний өдрийн дотор зарим сумдад ажиллан, ажлын үр дүнг 2022 оны 11 дүгээр сарын 20-ний өдрийн дотор танилцуулж, тайлан мэдээг холбогдох газруудад хүргүүлж ажиллахыг ажлын хэсэг (П.Мөнхжаргал)-т үүрэг болгосугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (П.Ариунбат)-т даалгасугай.

ДАРГА

Ш.ИДЭРБАЯСГАЛАН

Аймгийн Засаг даргын 2022 оны 10 дугаар
сарын 04-ний өдрийн 433/2 дугаар
захирамжийн хавсралт



АЖЛЫН ХЭСГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Ажлын хэсгийн ахлагч: П.Мөнхжаргал- (Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга)

Гишүүдэд:

Б.Золжавхлан-(Хөвсгөл нуур, Эгийн голын сав газрын захиргааны даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Ё.Батсайхан –(Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтсийн мэргэжилтэн)

Б.Өнөрбаяр-(Дэлгэрмөрөн, Шишхэд голын сав газрын захиргааны ахлах мэргэжилтэн)

Б.Даваасүрэн-(Мэргэжлийн хяналтын газрын хэлтсийн дарга Байгаль орчны хяналтын улсын байцаагч)

А.Үнэнбаяр- (Аймгийн Ус, цаг уур, орчны шинжилгээний төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч)

Б.Эрдэнэдалай (Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын газар зохион байгуулалт, төлөвлөлт хариуцсан ахлах мэргэжилтэн)

Л.Мөнхбаатар-(Цагдаагийн газрын Экологийн асуудал хариуцсан эрүүгийн ахлах мөрдөгч, цагдаагийн ахмад)

Т.Одгэрэл-(ЗООНОЗ өвчин судлалын төвийн ариутгагч)

Нарийн бичгийн дарга:

Д.Дамцагдулам – (Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын ус хариуцсан мэргэжилтэн)

_____оОо_____